



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/606

Булган сум

┌ **Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг** ┐
цуцлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 11.6 дахь заалт, Монгол Улсын Шадар сайд, Булган аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 онд хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль" зохион байгуулагдаж дууссан тул 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цагаас эхлэн гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдал"-ын зэргийг цуцалсугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, алба болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны ажлын тусгай горим, "Гамшгийн иж бүрэн сургууль"-ийн үр дүнг тайлагнахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

